



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.02 № 01/689  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
УЛААН-УУЛ СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНЫ ДАРГА  
Б.ОРНОБИШ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Монгол Ардын намын хорооны ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (16 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Монгол Ардын намын хороонд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт 16 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



# МОНГОЛ АРДЫН НАМ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ СУМЫН

ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АГУУЛГА:

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО



1.1. ЭРҮҮЛ ИРГЭН

1.2. ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ

1.3. ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ ӨВ СОЁЛ, СПОРТ

1.4. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

**ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

2.1. МАЛ АЖ АХУЙ ҮЙЛДВЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭЛТ

2.2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЖИЛТ

2.3. ТӨСӨВ САНХҮҮ

2.4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

**ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО:**

3.1 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

3.2 БИЛЧЭЭР АШИГЛАЛТ

**ДӨРӨВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО:**

4.1. ДЭД БҮТЭЦ

4.2. БАГИЙН ХӨГЖИЛ ТОХИЖИЛТ

**ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО:**

Сумын МАН-ын хорооны Тэргүүлэгчдийн



2024 оны ...р сарын ...өдрийн .....р тогтоолоор батлав.


**Улаан-Уул сумын ИТХ-ын 2024 оны сонгуульд МАН-аас**  
**дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр**

**МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:**

- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ МУ-ын алсын хараа – 2050 хөгжлийн хөтөлбөр
- ✓ Хөгжсөн Хөвсгөл 2030 хөтөлбөр
- ✓ Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
- ✓ 2024 оны УИХ болон аймгийн ИТХ-ын сонгуульд МАН-аас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр.
- ✓ Улаан – Уул сумын ард иргэдийн санал.

**УРИА: "УНАГАН НУТГИЙНХАА ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА"**


**ЗОРИЛГО: Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж орон нутгийнхаа хөгжлийг шинэ шатанд гарган, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлнэ.**



0000000003

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО****Хүний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэнэ.****1.1. ЭРҮҮЛ ИРГЭН:**

- 1.1.1 Сумын эрүүл мэндийн төвийн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтэй боловсон хүчнээр бүрэн хангаж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.2 Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, яаралтай тусламжийн сүлжээний чадварыг дээшлүүлэн эмийн сангийн нэн шаардлагатай эмийн хангамжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.3 Орон нутгийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг бэхжүүлж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлж, чадварлаг, ёс зүйтэй хариуцлагатай хүний нөөцийг төлөвшүүлнэ.
- 1.1.4 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй зохион байгуулана.
- 1.1.5 Иргэн бүр эрүүл мэндийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд бүрэн хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллана.
- 1.1.6 Сумын эрүүл мэндийн төвийн шаардлагатай тоног төхөөрөмж багийн эмч нарын унаа мотоцикл, хатуу зөөлөн эдлэл бусад шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангах ажлыг үе шаттай шийдвэрлэнэ.
- 1.1.7 “Эмийн зохистой хэрэглээ” аяныг жил бүр зохион байгуулж, нэн зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлж, эмийн чанар, аюулгүй байдалд тавих, иргэд олон нийт төрийн хяналтыг сайжруулана.



0000000004

1.1.8 Эмнэлгийн эмч ажилтан ажиллагсдын нийгмийн асуудлыг тодорхой төвшинд дээшлүүлэн тэднийг гадаад дотоодын чадавхжуулах мэргэшүүлэх сургалтуудад хамруулахыг дэмжиж ажиллана.

1.1.9 “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлж шүдний кабинетийн тоног төхөөрөмжийг бүрэн хангана.

1.1.10 Эрүүл мэндийн төвийн барилгыг бүрэн шинэчилнэ.

## 1.2. ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ

1.2.1 Хүүхдийн сурах хөгжих эрүүл аюулгүй ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэгдсэн тодорхой ажлуудыг зохион байгуулж дотуур байр, хичээлийн байр, анги танхимын хүрэлцээ хангамж хүчин чадлыг бүрэн ашиглаж 6 настай хүүхдийн амьдрах сурах нөхцлийг улам сайжруулна.

1.2.2 “Боловсролын шинэчлэл” хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж орчин үеийн цахим интернэтийн орчинг нэмэгдүүлнэ.

1.2.3 Хөгжмийн болосролын танхим, Мэдээлэлзүйн кабинет, Гадаад хэлний кабинетийг шинээр байгуулан тохижуулж тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.

1.2.4 Сумын спорт залыг шинээр барьж спортын хэрэгсэл хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжөөр бүрэн хангах

1.2.5 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдвал зохих хүүхдүүдийг бүрэн хамруулж шинэ барилгын тохижилт соёлжилт, хүүхдэд ээлтэй орчин нөхцлийг бүрдүүлэн ажиллана.

1.2.6 Үндэсний бөх, тэшүүр, хөнгөн атлетик, урлагийн дуулах авьяас чадварыг түлхүү хөгжүүлж ахисан шатны секц дугуйлан тогтмол хичээллүүлэх, уралдаан тэмцээнд оролцуулах ажилыг дэмжиж ажиллана.

1.2.7 Хичээлээс гадуурх сургалтыг үндэсний хөтөлбөрийн дагуу явуулж, сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон секц, дугуйлангийн үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд дэмжих бодлого баримтална.




0000000005

- 1.2.8 Багш нарын мэргэжил ур чадварын хөгжлийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаанд хамруулж, “Үе үеийн залгамж” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж тэдний нийгмийн асуудалд анхаарал дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.2.9 Боловсролын хууль, өөрчлөлт шинэчлэлийн бодлогыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахад онцгой анхааран ажиллана.
- 1.2.10 Багш нарын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, тэднийг гадаад дотоодын сургалтанд хамруулан чадавхижуулах чиглэлээр дэмжиж ажиллана.
- 1.2.11 Цэцэрлэгийн хүүхдийн хоол болон сургуулийн үдийн хоолны стандарт, чанарт өөрчлөлт гаргах, орц найрлагыг нэмэгдүүлэх, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү, сүүн бүтээгдэхүүнээр үйлчлэхийг зорино.
- 1.2.12 Хөдөөгийн багуудад зуны цэцэрлэгийн байруудыг засварлах, шинэчлэх асуудлыг шийдвэрлэх, орчны тохижилт, аюулгүй байдлыг сайжруулах асуудлыг дэмжин ажиллана.

### 1.3 ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ ӨВ СОЁЛ, СПОРТ

- 1.3.1 Соёлын төвийн орчин нөхцөл техник хэрэгсэл материаллаг баазыг бэхжүүлж иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар давтамжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.2 Орон нутагт тэргүүлэх чиглэлийг болон үндэсний спортын төрлүүдийг түлхүү хөгжүүлж нийтийг хамарсан спортын арга хэмжээг өргөжүүлнэ.
- 1.3.3 Хөдөөгийн багуудын “Мэдээллийн төв”-үүдийг ширээ сандал техник хэрэгсэл тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.
- 1.3.4 Түүх, соёлын өвийг хайрлан хамгаалах, баяжуулан өргөжүүлэх биет болон биет бус өвийг хамгаална. Орон нутаг судлах музейнүүдийг жил бүр сан хөмрөгийг арвижуулан өв соёлоо түгээн дэлгэрүүлж дэмжиж ажиллана.



1700050001 0070605


0000000006



- 1.3.5 Монголынхоо нүүдлийн соёл иргэншил, үнэт зүйлийг танилцуулсан өв соёл, урлаг, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд орон нутгийн дунд хугацааны хөтөлбөр боловсруулж ажиллана.
- 1.3.6 Соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж ажиллуулна.
- 1.3.7 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэж, соёлын биет ба биет бус өвийн мэдээллийн санг баяжуулж, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.
- 1.3.8 Сумын төвд хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх 3x3 сагсан бөмбөг болон хөл бөмбөгийн талбай шинээр байгуулахыг дэмжинэ.


#### 1.4 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 1.4.1 Баялаг бүтээгчдийг төрийн бодлогоор дэмжиж нутгийн бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд онцгой анхаарч ажиллана.
- 1.4.2 Өрх толгойлсон эмэгтэйчүүдийг үйлдвэрлэл бичил бизнес эрхлэхэд дэмжиж өрхийн амжиргааны түвшин тогтоох аргачлалыг үндэслэн нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтод бүлэгт шилжүүлнэ.
- 1.4.3 Их дээд сургууль төгссөн залуучуудаа сумандаа эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэж, цахим мэдээллийн систем, хөдөлмөрийн мэдээллийн санг бий болгоно.
- 1.4.4 Гэр бүл хүүхэд оюутан залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцлийг сайжруулж шинээр бий болгоход онцгой анхаарч тэдний хэрэгцээг дэмжсэн хөтөлбөрүүдийг орон нутагтаа боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.4.5 Эрэлттэй ажлын байрны судалгаа гаргаж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар шат шатны байгууллагуудтай хамтран сумандаа дунд, богино хугацааны хөтөлбөр боловсруулж залуучуудыг хамруулна.



0000000007

- 1.4.6 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зорилтод бүлгийн өрхийн нэн тэргүүнд хамруулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжүүлэх дэмжих хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх тэднийг хэрэгцээт үйлчилгээ авах нөхцөлийг төрийн болон бусад байгууллагуудад бүрдүүлж ажиллана.
- 1.4.7 Ахмадын мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх “ Зөвлөх үйлчилгээ”-г үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулж ахмадын үлгэр дуурилал өдөрлөгийг тогтмолжуулан байгуулга бүрт хариуцуулан ажиллана.
- 1.4.8 Ахмадын талаарх төрийн бодлого хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж ахмадад үзүүлэх амралт сувилал хөнгөлөлт үйлчилгээнд хамруулах ажлыг дэмжиж ажиллана.
- 1.4.9 Хүн амынхаа нийгмийн бүлэг /хүүхэд, залуучууд, ахмад настан, эхчүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ бүрт чиглэсэн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэнэ.
- 1.4.10 Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшинг бууруулах бодлого баримтлана.
- 1.4.11 Төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж үйлчилгээг зөвхөн зорилтод бүлэгт чиглүүлж ажиллана.
- 1.4.12 Байгалийн баялагийн сангийн тухай хуулийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, иргэн бүрийн нэрийн дансны хуримталалыг арвижуулан, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны асуудлаа шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэнэ.



0000000008

1.4.13 Эрүүл мэнд биеийн тамир спортын гадна цогцолбор талбайг сургууль цэцэрлэгийн орчинд шинэчлэн байгуулна.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

### **2.1. МАЛ АЖ АХУЙ ҮЙЛДВЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭЛТ**

2.1.1 Малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр орон нутгийн дэд хөтөлбөр, Хөдөө аж ахуйн салбарт малчдын залгамж халааг бэлтгэх

2.1.2 “Залуу малчин гэр бүл”-ийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллана.


2.1.3 Хувийн хэвшлийн мал эмнэлэгүүдийн чадавхийг бэхжүүлж, мал амьтаны гаралтай өвчний голомтыг устгах, ариутгах, халдваргүйжүүлэх, ажлын чанар үр дүнг дээшлүүлж, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулна.

2.1.4 Малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим хүртээмжийг сайжруулна.

2.1.5 Сумын эдийн засагт нөлөө үзүүлэхүйц орон нутгийн түүхий эдэд түшиглэсэн томоохон болон жижиг дунд үйлдвэрлэлүүдийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, сум хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сан, бусад сангуудын үйл ажиллагааг сайжруулан, хөгжлийг дэмжих бодлого баримтална.

2.1.6 Мал, амьтны гаралтай арьс, шир, үс, ноос, ноолуурыг боловсруулах жижиг цех, үйлдвэрийг бодлогоор дэмжин төсөл хөтөлбөрт хамруулна. Үүнд:

- Дархад үүлдрийн хонийг өсгөх
- Хөх сарлагаа үржүүлж хөөврийг самнаж, ашиглах худалдаалах
- Дархад цагаан адууны судалгаа оношилгоог хийж өсгөж үржүүлэх ашиг шимийг хүртэх.



0000000009

2.1.7 Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэхийг иргэддээ уриалж, худалдан авалтанд орон нутгийн үйлдвэр, бизнес эрхлэгчид оролцохыг дэмжинэ.

2.1.8 Мах боловсруулах, хадгалах, худалдаалах стандартын цех барьж ашиглалтанд оруулна.

2.1.9. Шинэ хөдөө төслийг орон нутагтаа тэгш хүртээмжтэй эрчимтэй хэрэгжүүлнэ.

2.1.10. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үнийн хөөрөгдлийг бууруулах чиглэлээр тогтмол анхаарч хяналт тавьж ажиллана.

2.1.11. Шинэ хөдөө төслийн хүрээнд малын тэжээлийн үйлдвэрийг байгуулах орон нутгийн өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

2.1.12. Ажлын байр олноор бий болгох, тогтвортой үйл ажиллагаа явуулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин хөгжүүлэнэ.

## 2.2 ТӨСӨВ САНХҮҮ

2.2.1 Төсөв санхүүгийн шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, санхүүгийн албаны ажилтнуудын чадавхыг дээшлүүлнэ.

2.2.2 Төсөвийн үр ашиггүй зардлыг танаж, хэмнэлтийн горимд шилжүүлж, төсвийг үр дүнтэй зарцуулж шилэн байдлыг хангана.

2.2.3 Татвар хураалтыг цахимжуулж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.

2.2.4 Шинээр ажлын байр нэмэгдүүлсэн иргэд, аж ахуйн нэгжийг татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогод хамруулахад анхаарч ажиллана.

2.2.5 Орон нутгийн орлогын хэмжээг нэмэгдүүлэх үр ашигтай зарцуулахад анхаарч байгалийн баялаг ашиглах мод модон бүтээгдэхүүн үйлдвэрлэх, жимс



0000000010

жимсгэнэ боловсруулах чиглэлээр орон нутгийн хөтөлбөр боловсруулж иргэн ААН – д дэмжлэг үзүүлж ажиллана.

2.2.6. Шинэ хоршоо төслийг хэрэгжүүлэх болон орон нутгийн хөгжлийн сан бусад сангуудын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулана.

### **2.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

2.3.1 Аялал жуулчлалыг сумын эдийн засгийн туслах салбарын нэг болгон хөгжүүлэх, орон нутгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.3.2 Дотоодын амрагч, аялагчдад зориудсан амралт зугаалгын бүсчлэлийг тогтоож, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, гар урлалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

2.3.3 Байгаль орчинд ээлтэй нутгийн иргэдийг түшиглэсэн тогтвортой эко аялал жуулчлалыг сумандаа хөгжүүлнэ.

2.3.4 Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу жуулчны отог байгуулахаар зөвшөөрөл авсан иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.


2.3.5 Дээд цагаан нуур, Өвөр Ушгадайн рашааныг амралт сувиллын газар болгох

### **ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО:**

#### **3.1 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН**

3.1.1 Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал, Байгаль орчны тасгийн ажлыг эрчимжүүлж орон нутагт ой модыг зөв зохистой ашиглах, хэрэглэх, хайрлах, хамгаалах, нөхөн сэргээх сумын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.

3.1.2 Сумын төвийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, гол горхи, булаг шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг үргэлжлүүлэн голуудын хамгаалалтын зурвасуудыг шинэчлэн тогтооно.



0000000011

3.1.3 Ган, зуд, гал түймэр, үер, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшгаас сэргийлэх, болзошгүй эрсдэлийг бууруулах, ажлын шинэ менежментийг хэрэгжүүлэнэ.

3.1.4 Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх, ойн түймэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэнэ.

## 3.2 БИЛЧЭЭР АШИГЛАЛТ

3.2.1 Газрын хуваарилалт олголтыг онцгой анхаарч сумын хэмжээнд шинэчилсэн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

3.2.2 Хөрс хамгаалалт газрын доройтлыг бууруулах билчээрийн хүртээмж нөхөн сэргээлтийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.2.3 Бэлчээр ашиглалттай холбоотой малчдын гаргасан санал хүсэлтийн хүрээнд багийн хилийн цэсийг дахин шинэчлэн тогтоох талаар анхааран зохих шатанд хүргэж ажиллана.


3.2.4 Шаардлагатай газарт худаг гаргаж, ойжуулах нөхөн сэргээх арга хэмжээг иргэд нөхөрлөлүүд төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх ажлыг хийж хэрэгжүүлнэ.

3.2.5 Сумын төвийн худгийн орчин нөхцөл эрүүл ахуйн байдал, орчны стандартын нөхцлийг сайжруулан шинэчилж тохижуулна.

3.2.6 Сумын нутаг дэвсгэрт байгаа гол горхи ус рашааныг бохирдлоос хамгаалах тогтмол үйл ажиллагаа зохион байгуулж ажиллана.

3.2.7 Сумын хэмжээний бүх хог бохирдлыг бүрэн цэвэрлэж хогийн нэгдсэн цэгийн орчин нөхцлийг тогтмол сайжруулж хяналт ажиллана.

3.2.8 Отрын нөөц билчээртэй болгох, нөөц билчээрийн хүрээнд худаг ус гаргах



0000000012

3.2.9 Багуудын билчээрийн хуваарилалт, хэрэглээг зохицуулах сумын билчээр ашиглалтын журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэн зөв зохистой ашиглах

**ДӨРӨВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО:**

**4.1. ДЭД БҮТЭЦ**

4.1.1 Сумын төвд иргэдийн амарч тухлах чөлөөт цагаа өнгөрөөх байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.1.2 Сумын төвд ахуйн үйлчилгээний үйлчилгээг бүрэн хүртэх боломжийг нэмэгдүүлж иргэд халуун ус, үсчин, гоо сайхан, хими цэвэрлэгээний үйлчилгээг тогтмол авах боломжтой болгоно.

4.1.3 Сумын төвийн үерийн эрсдэлтэй бүсүүдэд үерийн далан барих тэнд амьдардаг өрхийн аюулгүй байдлийг хангах ажилуудыг нэмэгдүүлнэ.


4.1.4 Сумын төв, хөдөөгийн хүн амыг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, үүрэн телефоны мэдээлэл дамжуулах үйлчилгээний технологийг нэмэгдүүлнэ.

4.1.5 Сумын төвийн иргэдийн аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлж, авто зам, гудамж, олон нийтийн зам талбайг гэрэлтүүлэх камержуулах ажлыг үргэлжлүүлж бүрэн шийдвэрлэнэ.

4.1.6 Зорчигч тээврийн олон төрөлт үйлчилгээ бий болгож, иргэдийн богино хугацаанд зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

4.1.7 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн нийтлэг шаардлагад нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулж, газар зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсронгуй болгон мөрдөнө.

4.1.8 Нэмэлийн хорооллыг эрчим хүчээр хангах ажлыг шийдвэрлэнэ.



0000000013

4.1.9 Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд “Сумын хөгжил инженерчлэлийн дэд бүтцийн хангамж” төслийг хрэгжүүлж иж бүрэн төвлөрсөн халаалтын шугам сүлжээгээр хангах

4.1.10 Орон нутгийн чанартай даваа зам гүүрүүдийг сайжруулна.

4.1.11 Гуны гол дээр Эрдэн толгойн гарамд шинээр гүүр, Багтагын голд бетонон гүүр барих, Өл тоомын давааны гүүрүүдийг бетонон гүүр болгон шинэчлэх.

4.1.12 Сумын төвд шинээр хашаа байшин, сууц барих ажилд иргэдэд дэмжлэг үзүүлж ажиллана.

4.1.13 Сумын төвийн камержуулалтыг бүрэн шийдвэрлэнэ.

4.1.14 Сумын төвд бетонон зам шинээр тавих: “Нутгийн зам” хөтөлбөр хэрэгжүүлэх

## 4.2. БАГИЙН ХӨГЖИЛ ТОХИЖИЛТ

4.2.1 Бүх багийн шаардлагатай зам засварын ажлыг хийж дуусгах:


- Шивлэгийн давааны зам засвар
- Тоом багийн Сэрхийн 5км зам засвар
- Соёо багийн Үхэртийн амнаас Цагаан бэлчир хүртэлх зам засвар

4.2.3 Шивлэг, Гун, Мунгараг багт үүрэн холбоотой болгох ажлыг нэмэгдүүлэх

4.2.4 Бүх багийн шаардлагатай хөцөө хашааг шинэчилж засварлана.

4.2.5 Малчдыг аялал жуулчлын үйлчилгээнд өргөн хамруулах

4.2.6 Малчдын нийгмийн асуудлыг сайжруулах, тэднийг төрийн үйлчилгээ, болон бусад төсөл хөтөлбөр, халамжийн үйлчилгээнд тэгш хамруулна.



0000000014



**ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО:****5.1 ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

5.1.1 Хүнд сурталгүй төрийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж төрийн албан хаагчдыг шат шатанд чадавхжуулж

5.1.2 Төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдийн чадавхийг сайжруулах

5.1.3 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж тушаал шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянах ажлыг эрчимжүүлнэ.


5.1.4 Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл ёс зүй сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

5.1.5 Төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг орон нутаг, төрийн албаны анхан шатны нэгжид ажиллуулан дадлагажуулах замаар мэдлэг чадвар туршлагыг нэмэгдүүлнэ.

5.1.6 Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар хандлагыг эрс шинэчилнэ.

5.1.7 Сумын онцгой комисс шуурхай штабын үйл ажиллагаанд мэдээлэл технологийн ололтыг нэвтрүүлж үйл ажиллагааг чанаржуулна.

5.1.8 Иргэний танхимыг техник тоног төхөөрөмжөөр хангаж иргэдэд Эрх зүйн зөвлөгөө өгөх, мэдээлэл сурталчилгааны ажлын чанар хүртээмжийн нэмэгдүүлнэ.



0000000015

5.1.9 Сумын хэмжээнд Гэмт хэрэг зөрчилгүй сум болох Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог дээшлүүлж хамтын ажиллагааг сайжруулж гэмт хэргийн гаралтыг тогтвортой бууруулна.

5.1.10 Цэрэг цагдаагийн байгууллагын хүний нөөц чадавхийг бэхжүүлж үйл ажиллагааг нь сайжруулж , орон нутагт тогтвор сууршилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

## 5.2 ТӨРИЙН АЛБА

5.2.1. Төрийн албаны ил тод нээлттэй тэгш хүртээмжтэй үйлчилгээг нэвтрүүлнэ.

5.2.2. Нутгийн захиргааны байгууллагын тогтоол, шийдвэр, гэрээ хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.

5.2.3. Орон нутагт авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ хандлагыг бүх нийтэд төлөвшүүлэнэ.

5.2.4. Төрийн албаны бүх шатанд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, тэдний нийгмийн баталгааны бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэнэ.

5.2.5. Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх иргэдийн цахим хэрэглээг чадавхижуулах

5.2.6 Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлнэ.

5.2.7. Орон нутгийн чанартай эрсдлээс сэргийлэх зорилготой галын машинтай болох асуудлыг шийдвэрлэнэ.



УЛААН-УУЛ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО.

 0000000016